

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 10 дахь хэсэг нэмсүгэй.

“10.Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашигладаг, Монголбанкнаас тогтоосон доод хэмжээний экспортын гадаад валютын орлоготойхуулийн этгээдийн төлбөр тооцооны дансыг Монголбанк өөр дээрээ байршуулж болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй.

“6/ хуульд тусгайлан заасан тохиолдолд хуулийн этгээдийн дансыг тодорхой нөхцлөөр өөр дээрээ байршуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

